



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 03 сарын 13 өдөр

Дугаар А/53

Улаанбаатар хот

Сонгинохайрхан дүүргийн 22 дугаар хорооны "Одонт манал" ӨЭМТ-ийн данс бүртгэлээс тээврийн хэрэгсэл хасах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 4 дүгээр зүйл, Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/172 дугаар захирамжийг үндэслэн ТУШААХ нь:

1. Ашиглалтын шаардлага хангахгүй болсон, засаж сэлбэх нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тогтоогдож, сэлбэгийн буюу хоёрдогч түүхий эдийн зориулалтаар татан төвлөрүүлж худалдахаар шийдвэрлэгдсэн 6,950,000 /зургаан сая есөн зуун тавин мянган/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий Ниссан Вингроуд маркийн 37-14 УНЕ улсын дугаартай тээврийн хэрэгслийг актлаж, данс бүртгэлээсээ хасахыг Сонгинохайрхан дүүргийн 22 дугаар хорооны "Одонт манал" ӨЭМТ /Л.Оюунчимэг/-д зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй тээврийн хэрэгслийг Өмчийн харилцааны газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг Сонгинохайрхан дүүргийн 22 дугаар хорооны "Одонт манал" ӨЭМТ /Л.Оюунчимэг/-т үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг үнэлж, худалдан борлуулах ажлыг зохион байгуулахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс /Х.Жаргалсайхан/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн бүртгэл, мэдээллийн хэлтэс /Д.Итгэл/-т тус тус даалгасугай.

ДАРГА



Ч.ОДНАСАН

• 115050000173